

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дадийн Норовсамбуу	Дугаар	L204
Оршин суугаа аймаг	Дорноговь	Оршин суугаа сум	Сайншанд 3-р баг
Төрсөн газар	Сулинхээр	Төрсөн он	1914
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Задгайтын хийд	Сүм хийдийн дугаар	ДГХБ 066
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Задгайтын хийд

Энэ хүн бол Задгайтын хийд дээр шавилан сууж байсан хүн юмаа. За Норовсамбуу гуай, та аль хийдэд шавилан сууж байсан хүн бэ?

Норовсамбуу: Задгайтын хийд

Гантулга: Хэдэн наснаасаа хэдэн насны хооронд?

Норовсамбуу: 7 наснаасаа л эхлээд л арван хэд хүртлээ, хурал тартал л байсан. Хэдэн онд билээ дээ... 27 онд ч билүү, мэдэхгүй

Гантулга: Та өөрөө хэдэн оны хүн бэ?

Норовсамбуу: Аан?

Гантулга: Та өөрөө хэдэн онд төрсөн хүн бэ?

Норовсамбуу: 1914 онд

Гантулга: Таны сууж байсан хурлын нэрийг хэлнэ үү?

Норовсамбуу: Задгайтын сүм

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Өөрөөр одоо нэрлэсэн юм байна уу?Гандан тэгчинлин сүм энэ тэр гэж нэрлэсэн юм байна уу?

Норовсамбуу:Чэдэглэн гэж байсан юм

Гантулга: Аан чэдэглэн.Хэдий үед ямар хүн байгуулсан тухай та мэдэх үү?

Норовсамбуу:Аа тэрийг би мэдэхгүй.100 гаруй жил л байсан гэдэг

Гантулга: Аан 100 гаруй жилийн настай ?

Норовсамбуу: Тийм

Гантулга:Одоо энэ хуучин байсан захиргаагаар нь хэлвэл аль хошууны хурал байсан юм бол?

Норовсамбуу:Аан

Гантулга: Аль хошууны хурал байсан бэ?

Норовсамбуу: Үгүй одоо...

Гантулга: Мэргэн Ван гэж байсан уу үгүй юу ?

Норовсамбуу:Мэргэн Ван гэж байсан.

Гантулга: Хийдийн ойр орчим байгаа , газар усны тодорхой нэрүүд?Уул усны нэрүүдийг , ойролцоох?

Норовсамбуу:За тэгээд Задгай шанд , зүүн хойно нь 7 шанд , хойно нь Баян хяр Тахилгат Баян цагаан энэ тэр гээд бий л дээ

Гантулга: Баруун талаар ?

Норовсамбуу: Задгайтын ус , Аман цагаан хойно ньрашаан гэж бий

Гантулга: Энэ мэргэн вангийн хошууны сүүлийн засаг ноён нь ямар хүн байсан бэ, хэн гэж хүн байсан бэ?

Норовсамбуу:Хэн?

Гантулга:Мэргэн вангийн хошууны засаг ноён?

Норовсамбуу: Аа мэдэхгүй ээ, мэдэхгүй өвөө нь . Миний багад үзэж дуулаагүй хүмүүс , тэгээд ч ардын засаг гарангуут цол хэргэмээ, мяндаг тушаалаа өгчихсөн юм гэнэ лээ.Өвөө нь мэдэхгүй

Гантулга:Энэ сүм хийд ер нь ямар жасаатай ойролцоо оршдог байсан бэ?

Норовсамбуу:За тэр Хорго гүний хурал гэж байсан юм.За тун ойрхон.хоорондоо 30, 30 дээр үед бол өртөө л гэдэг байсан юм даа , одоогоор бол 30, 30 км байсан юм

Гантулга: Ер нь холбоо харилцаатай байсан , хоорондоо ирж очдог сүм хийдийг нэрлэвэл?

Норовсамбуу: Хоорондоо холбоотой гэвэл одоо тэр Таван булаг, Цагаан булаг хоёртой л холбоотой л байсан юм даа

Гантулга: Энэ өвөр монголын бас нэг хуралтай бас холбоотой байсан гэж та түрүүн хальт хэлсэн?

Норовсамбуу: Аа холбоотой

Гантулга: Тэр бол эндээс хол уу?

Норовсамбуу: Өө хол , тэр бол базаахгүй базарваани . Дээр үеэс ингэж холбоотой байсан юм

Гантулга: Хэдэн лам хуврагтай байсан бол?

Норовсамбуу:Хэдэн лам хуврагтай хийд байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норовсамбуу: Хэдэн ламтай гэжүү, 200-аад

Гантулга: Голдуу аль хошуу сумаас ирж шавилдаг байсан бол?

Норовсамбуу: Өө энэ хошуунаасаа л

Гантулга: Задгайтын хийдийн хутагт хувилгаанууд нь ямар хүмүүс байсан бэ?

Норовсамбуу:Цорж лам , Ширээт лам гэж 2 лам байсан юм

Гантулга: Нэртэй эрдэмтэн лам нар?

Норовсамбуу:Аан ?

Гантулга:Нэртэй том эрдэмтэн лам нар?

Норовсамбуу: За одоо энэ чинь хэн гэх юм бэ дээ, миний багш л юм даа

Гантулга: Нэрийг нь хэлж болохгүй юу?

Норовсамбуу: Аа болохгүй

Гантулга: Нэр усаар нь хэлж болохгүй ?

Норовсамбуу: /инээв/ Тэр 200-аад хүн дотор чинь байсан л байлгүй

Гантулга: Нэртэй зурхайч?

Норовсамбуу:Төрөө зурхайч байсан юм

Гантулга:Нэртэй маарамба , бурхан бүтээгч одоо бурханч?

Норовсамбуу: Юу?

Гантулга: Бурханч гэж байдаг ш дээ, бурхан зурдаг?

Норовсамбуу: Аа тийм онц нэртэй юм байхгүй

Норовсамбуу: Дандаа хятад улсууд зурдаг байсан юм

Гантулга: Нэртэй эмч маарамба?

Норовсамбуу: Тэр таван булгийн хурлын тэр нэг эмч хүн байсан юм

Гантулга: Ямар хүн байсан юм?

Норовсамбуу:Маарамба лам гэж...

Гантулга:Цагаан булгийнх?

Норовсамбуу: Цагаан булагт эмч хүн байгаагүй ээ

Гантулга:Ер нь лам нь ямар хүн байсан юм

Норовсамбуу: Аа Ёндон гэж хүн байсан юм

Гантулга: Ер нь олон ламтай байсан уу, тэр Цагаан булаг?

Норовсамбуу:Аа нэг 20- иод л ламтай байсан

Гантулга: Хичнээн дуган дацантай ?

Норовсамбуу: Хоёр л сүмтэй

Гантулга: Ер нь аль чиглэлийн хурал байсан юм?

Норовсамбуу : Мянган сүмийн хурал гэж байсан юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Мянган сүмийн ?

Норовсамбуу: Тийм .Мянган сүмийн хурал л гэдэг байсан юм гэнэ лээ

Гантулга: Цорж лам , Ширээт лам ловон , гэлэн , даа лам , унзад , гэвш эд нарт нь ямар улсууд байсан юм?

Норовсамбуу: За одоо халагдаж солилцоод л байдаг юм ш дээ, тэднүүд чинь

Гантулга: Нэг хүн байж байгаад л өөр хүн болоод л ?

Норовсамбуу: Тийм тэгээд л тэд нар чинь солигдоно, халагдана, өшөө тэнцэхгүй бол бас халагдана

Гантулга: Сүүлийн байж байсан улсуудаас нь нэрлэвэл?

Норовсамбуу: Аан

Гантулга:Хамгийн сүүлд таныг байхад байсан тийм улсуудаас нь нэрлэвэл?

Норовсамбуу: Тэр Дондов ловон гээд байсан, баригдсан ...

Гантулга: Цогчин?

Норовсамбуу: Цогчин гэвш нь Жадамба гэж хүн байж байгаад баригдсан.

Гантулга: Унзад нь?

Норовсамбуу: Унзад ч одоо их олон хүн байсан даа. Баригдсан юм байхгүй байхаа тэр.

Гантулга: Даа лам?

Норовсамбуу: Даа лам ч одоо тийм тоймтой юм биш шүү дээ

Гантулга: Бас л баригдсан?Та тэр цогчингуудаа сайхан нэрлээд өгөхгүй юу, эхнээс нь .Барууны зүүний цогчин гээд ?

Норовсамбуу: Барууны цогчин дотроо Гүмбэ дуган, ганжуурын данжуурын гээд ...Донжидын сүм гэж байна уу?

Гантулга: Донжидынх гэж байхгүй , ловон?

Норовсамбуу: Тийм, ловон гэж бий .

Гантулга: Жасаан сүм ?

Норовсамбуу:Жасаан сүм гэж бий

Гантулга :Мамба сахиусын ?

Норовсамбуу: Тэр Донжидын сүм биш, жасаан сүм яг мөн

Гантулга: Тэгээд дацангууд нь ?

Норовсамбуу:Дүйнхор дацан

Гантулга: Чойр?

Норовсамбуу: Чойр

Гантулга: Жүд?

Норовсамбуу: Жүд, Мамба тэгээд л болж байгаа байх

Гантулга: Тэгээд нүгнээгийн хурал гэж болдог байх?

Норовсамбуу:Тийм болдог байсан

Гантулга: Тэгээд суварган сүм гэж?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норовсамбуу: Тийм

Гантулга: Цанидын сүм гэж ?

Норовсамбуу: Аан ?

Гантулга: Тийм цанидын сүм гэж байсан.

Гантулга: Ийм ийм л дуган дацангууд байсан уу?

Норовсамбуу:Тийм

Гантулга: Цогчин бүрдээ жастай юу?

Норовсамбуу :Тийм, цогчин болгондоо л жастай байсан.

Гантулга: Зүүн цогчин , баруун цогчин гээд?

Норовсамбуу: Тийм

Гантулга: Дацангууд нь Чойрынх нь бол Чойрын номоо л хурна?

Норовсамбуу:Тэгнэ

Гантулга: Мамбынх бол маарамбаар?

Норовсамбуу : Тийм

Гантулга: Дүйнхор нь дүйнхороор?

Норовсамбуу : Тийм

Гантулга: Хичнээн суваргатай байсан бэ?

Норовсамбуу: Зүүн талдаа хоёр суварга, баруун талдаа хоёр суварга байсан .Хойно нь хоёр суварга байсан

Гантулга: Ном баралдаг тийм газар байсан уу?

Норовсамбуу:Үгүй ор ч байгаагүй

Гантулга: Зүгээр бар хийдэг энэ тэр газар байгаагүй юу?

Норовсамбуу: Үгүй

Гантулга: Та өөрөө аль дацангийнх нь хүн байсан бэ?

Норовсамбуу: Би Чойр

Гантулга: Чойрт хэр олон жил болсон?

Норовсамбуу: Тоолж байгаагүй .Мэдэхгүй

Гантулга:Цогчин дуганд хурдаг байсан уу?

Норовсамбуу: Юу гэнэ ээ?

Гантулга: Цогчин дуганд хурдаг байсан уу, та?

Норовсамбуу: Хурна. Тэр цогчинд хэдэн жил хамаагүй сууна, тэгээд хурал болгоноор цогчин дугандаа хурна

Гантулга: Тэгээд дарааллаад л Чойрын дацан луу?

Норовсамбуу: Тийм .Тэгээд цогчингоосоо чойр луу, эсвэл цогчингоосоо мамба руу ч юмуу тэгээд л шилжээд л явна. Урагшаа ч юмуу, хойшоо ч юмуу явна

Гантулга: Цогчин дуганд ямар лам хурдаг байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норовсамбуу:Өө тэр чинь миний мэдэх гавж болсон Новуухонгор эд нар чинь цугаараа хурна

Гантулга:Сар болгоны дүйчэн өдрүүдэд ямар хурал хурдаг байсан?Цогчин дуганд шинийн найман , арванд, арван таванд ?

Норовсамбуу: Өө тэр сар болгон тийм юм байхгүй . Зүгээр дацан дээрээ л хурна

Гантулга: Тэгээд дацан дээрээ юу юу хурах уу, өдөр болгон хурах уу?

Норовсамбуу: Өдөр бүр хурна. Тэгээд сар болгоны тэр дүйчэн өдрүүдэд бо их болно

Гантулга: Дацан дээрээ юу?

Норовсамбуу :Тийм.Чойрын хурал бол одоо шинийн найманд одоо юэ гэдэг ч билээ майдар цам ч юмуу, за арван таванд Дарь эхийн хурал ч юмуу гэх мэтээр хурлыг хурна

Гантулга: Хорин таванд?

Норовсамбуу: Хорин таванд Найданчог , , Дандий Чува энэ хэдийг л хурдаг юм даа. Тэр аль аль дацанд нь хурж байсан мэдэхгүй .

Гантулга: Хорин есөнд?

Норовсамбуу : Хорин есөнд тийм хурал болохгүй ээ. Хорин есөнд чинь тэр одоо... өвлийн адаг сарын хорин есөнд л гүйцэд сор тавьдаг. Энэ цогчинд

Гантулга: Ер нь сар бүрийн гучинд , битүүнд ямар хурал хурах вэ?

Норовсамбуу : Байдаг хурлууд л хурна

Гантулга: Жилдээ одоо нэг удаа хурдаг том хурлуудаас нэрлэвэл?

Норовсамбуу:Найдан Чог, Үзүүгэйн Чог

Гантулга: Тэр нь хэзээ болдог бол?

Норовсамбуу:Найдан Чог нь зуны эхэн сард хурдаг. Тэр Үзүүгэйн Чог нь одоо энэ 6 сард хурдаг юм.Хуучны 6 сард

Гантулга: Тэгээд зургаан сарын хурал?

Норовсамбуу: Тийм зургаан сарын хурал .Тэгээд л ер нь сар бүр л хурна

Гантулга: Зуны адаг сард нь хурах уу?

Норовсамбуу: Хурна аа

Гантулга: Бас зун хурах уу?

Норовсамбуу: Тэгнэ

Гантулга: Майдар эргэдэг байсан уу?

Норовсамбуу: Эргэнэ ээ.

Гантулга: Майдар чинь яг яаж эргэдэг байсан юм бэ?

Норовсамбуу:Юу яаж эргэдэг гэж...

Гантулга: Ямар зан үйл хийж одоо эргэдэг байсан бэ?

Норовсамбуу: Үгүй яахав сүсэгтнүүд тойрч суучихаад л ...голоор нь ногоон морьтой майдар явна

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Хичнээн лам оролцдог байсан бэ?

Норовсамбуу: 200-аад лам. Тэгээд чадалтай лам нар нь л ордог байсан юм даа

Гантулга: Ганжуур эргэдэг байсан үү?

Норовсамбуу: Эргэнэ ээ

Гантулга: Лам нар нь эргэх үү, сүсэгтнүүд эргэх үү, мөргөж?

Норовсамбуу: Энэ чинь одоо Ганжуур эргэнэ гээд л авчаад л тэгээд номлолоо явж байгаа юм. Тэгээд л 108 ганжуур эргэхээр чинь номнуудаа солино.

Гантулга: Тэгээд нөгөө хүрээнийхээ голоор л эргэх үү?

Норовсамбуу: Тийм голоор л эргэнэ.

Гантулга: Унаа маланд ачааллаж холуур эргэх үү?